



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/дсб

Улаанбаатар хот

Явуулын нэг цэгийн үйлчилгээ
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн өртөө, зөрлөгийн шугам замын иргэд, малчин, мал бүхий айл өрхүүдэд “Явуулын нэг цэгийн үйлчилгээ”-г 2025 оны 10 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.“Явуулын нэг цэгийн үйлчилгээ” үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, явах замын маршрутыг хоёрдугаар, зарцуулах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.“Явуулын нэг цэгийн үйлчилгээ” үзүүлэхэд зарцуулагдах 813,040 (найман зуун арван гурван мянга дөр) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.“Явуулын нэг цэгийн үйлчилгээ”-г үзүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.


5.“Явуулын нэг цэгийн үйлчилгээ”-г чанар хүртээмжтэй хүргэж, тайлан, мэдээг нэгтгэж танилцуулахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 08 ны өдрийн
426 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн

ахлагч:

Гишүүд:

Х.Цогцэцэг

Н.Нямзав

Б.Батзориг

Ч.Магадсайхан

Д.Энхтайван

М.Уранцэцэг

Х.Ганбат

Нарийн бичиг:

Б.Гэрэлцолмон

Засаг даргын орлогч

1 дүгээр хорооны Засаг дарга

2 дугаар хорооны Засаг дарга

Газар зохион байгуулалтын албаны дарга


Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын дарга

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга


Эрүүл мэндийн төвийн дарга

Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 08 ны өдрийн
8/до6 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



1 ДҮГЭЭР ХОРООНЫ МАЛЧИН ӨРХ БОЛОН
ШУГАМ ЗАМЫН ӨРХӨӨР ЯВАХ МАРШРУТ



2 ДУГААР ХОРООНЫ МАЛЧИН ӨРХ БОЛОН ШУГАМ ЗАМЫН ӨРХӨӨР ЯВАХ МАРШРУТ



Нийт туулах замын км-Талдаа $173 \times 2 = 346$ км

лийн Багахангай дүүргийн
25 оны /О. дугаар сарын
гаар захирамжийн гуравд

ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Материалын нэр	Нийт явах километр	Хэмжих нэгж	100 Км-т зарцуулах хэмжээ	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун (92 бензин)	800 км	л	16 л	128 л	2590	331,520
2	Шатахуун (92 бензин) ЭМТ-ийн автомашин	800 км	л	16 л	128 л	2590	331,520
3	Фото цаас	-	Боодол	-	2	20,000	40,000
4	Принтерийн хор (өнгөт)	-	Ширхэг	-	6	15,000	90,000
5	Бичгийн цаас	-	Боодол	-	1	20,000	20,000
	Нийт						813,040